

Орон бүхний пролетари нар тусдаа АНХААГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 86 (2390)

1974 оны 11 дүгээр сарын 21

ПҮРЭВ

ХӨДӨЛМӨРЧДИЙН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөрчдийн өсөн нэмэгдэж байгаа өдөр тутмын эрэлт шаардлагыг хангахад сайн зохион байгуулагдсан хөнгөн шуурхай, соёлч боловсон ахуйн үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Манай нам, засгаас хүн амын ахуйн үйлчилгээний ажлыг өргөжүүлэн хөгжүүлэх, хөдөөгийн хөдөлмөрчдөд ахуйн үйлчилгээг хүргэх, ахуйн соёлжилтыг сайжруулж материаллаг баазыг нь бэхжүүлэх талаар ихээхэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

1974 оны 4 дүгээр сард МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс хөдөлмөрчдийн ахуйн үйлчилгээг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол гаргалаа. Уг тогтоолд хүн амын ахуйн үйлчилгээний ажлыг бүх талаар хөгжүүлэн, материаллаг баазыг нь бэхжүүлж, боловсон хүчнээр ханган, үйлчилгээг соёлч боловсон, хөнгөн шуурхай олгон чанаржуулах асуудал нам, улс, олон нийт, дээр, аж ахуйн байгууллагын анхаарлын төвд х чухал зорилт гэж заасан нь хүн амын ахуйн үйлчилгээний ажил зөвхөн ахуйн үйлчилгээний салбарын зорилт төдийгүй бүх нийтийн үйлс болохыг гэрчилж байна. Тус аймгийн хүн амын ахуйн үйлчилгээний ажлыг аймгийн НААУ-ний газар, ахуйн үйлчилгээний комбинат, Баянчандмань, Баяндэлгэр сумдад ахуйн үйлчилгээний анги, Жаргалант, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэ, Мөнгөнморьт зэрэг 12 суманд захиалга хүдлэн авах, гутал засварлах цэгүүд хариуцан хийж байна.

Аймгийн нийт хөдөлмөрчдийг ахуйн үйлчилгээгээр хангах, ахуйн үйлчилгээний үйлчлэх хүрээг өргөтгөх, ялангуяа хөдөөгийн хүн амд үйлчилгээг улам ойртуулах үндсэн дээр тус аймгийн НААУ-ний газрын харьяанд ахуй үйлчилгээний комбинат байгуулагдсан ба тус комбинат нь хивс, оёдол, үйлчилгээ, гутал, төмөр, халуун ус, угаалга зэрэг 6 цех тасгатай, 250 гаруй ажилчин, албан хаагчидтайгаар үйлд эрлэл үйлчилгээг явуулж байна.

Манай нам, засаг, хүн амын ахуйн үйлчилгээний ажлыг хөгжүүлэх, ахуйн үйлчилгээг эрхлэн явуулдаг үйлчлэгч ажилтан ажилчдын талаар ихээхэн анхаарал халамж тавьж байна. Саяхан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар «БНМАУ-ын үйлчилгээний гавьяат ажилтан» цол буй болгож тус улсын нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг өргөжүүлэн бэхжүүлэх, нэр төрлийг олшруулан, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласан нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилчин, ажилтан нар уг цолыг олгож байхаар тогтоосон дээр МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1976 онд нийтийн аж ахуй үйлчилгээний тэргүүний ажилчдын улсын зөвлөлгөөнийг хийлгэхээр шийдвэрлэсэн билээ. Нам засгийнхаа энэхүү анхаарал халамжийн хариуд тус аймгийн ахуйн үйлчилгээний олон зуун ажилтан, ажилчид идэвх чармайлт мэдлэг боловсролоо дайчлан ажиллаж ажлын өндөр амжилт гаргасаар байна.

Тус аймгийн ахуй үйлчилгээний байгууллагын хамт олны дотроос Зуунмод хотын ахуй үйлчилгээний комбинатын оёдолчин Дашсэрмаа, Хийшгхүү, Ш.Дарьсүрэн, төмөрчин Ж.Банзрагч, А.Должинсүрэн, Баяндэлгэр сумын ахуй үйлчилгээний ангийн оёдолчин До.Цэвэгмэд, Да.Цэвэгмэд нарын зэрэг 25 хүн V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 1 жил 2 сараас 2 жил 4 сарын өмнө биелүүлсэн ба энэ оны жилийн төлөвлөгөөг 2—3 сарын өмнө 93 ажилчин биелүүлж жилийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 45 хоногийн өмнө 100,2 хувиар, аж ахуй үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 102,2 хувиар тус тус биелүүлэн хөдөлмөрийн бахдам сайхан амжилт гаргалаа. Нам засгаас хүн амын ахуй үйлчилгээний ажлыг өргөжүүлэн хөгжүүлэх талаар тавьж байгаа зорилтыг амьдралд тууштай хэрэгжүүлэн ахуй үйлчилгээний ажлын арга хэлбэр, үйлчилгээний чанар, чиглэлийг сайжруулж, бүтээгдэхүүн-бүрийг соёлч байдлыг хөгжүүлэх явдал ахуй үйлчилгээний байгууллага, ажилтан, ажилчдын нэн чухал зорилт болж байна.

ЖИЛЭЭР ТҮРҮҮЛЭГЧИД

Нарстайн хоньчин, Шунхлайн ногоочин, Бөөрөлжүүтийн тариаланч, Туулын үхэрчин цөм л түүхт ой, хүндэт зочныхоо айлчлал угтсан хөдөлмөрийн ээлжиндээ бахдам амжилт гаргаж байгаагийн дотор «Эрдэнэ уул» бригадын саальчин Г. Должин, М. Самбүд, Ш.Цэцгээ, Ж.Нацагханд, «V таван жилийн гавш-

гайч» аварга кино механикч Гүржав, улсын аварга комбайнч Г. Батсүх, Загдгараа, Цэрэндорж, ногоочин Өлзийбуян, комбайнч Т.Эрдэнээ, тракторч Данший, сумын аварга, тракторч-комбайнч Нанжиддорж, ТАА-н аварга комбайнч Доржсүрэн нар V таван жилийн төлөвлөгөөг 1 жил гаруйн өмнө биелүүлээ.

Д.ОТГОН

ЯРУУ АЛДАРТ ХАГАС ЗУУНЫ ОЙ

БАЯРЫН ХУРАЛ БОЛОВ

БНМАУ-ыг капиталист биш замаар хөгжүүлэх жанжин шугамыг батласан МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны хагас зуун жилийн ойг ёстон тэмдэглэх Зуунмод хотын нам, улс, олон нийт, үйлдвэр, аж ахуйн байгууллага, хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн баярын хурал энэ сарын 18-нд аймгийн Соёлын ордонд боллоо.

Хурлын тэргүүлэгчдийн байранд таван хушуу, БНМАУ-ын сүлд, «50 жил» гэсэн үсгийг тайзны цэнхэр фононы наад талд улаан туузны дээр товойлон байрлуулж түүний доод талд их жанжин Сүхбаатарын баримлыг амьд цэцгээр чимэглэсэн байв. 15 цаг болоход хурлын тэргүүлэгчдийн байранд аймгийн Намын хорооны товчоо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийг гарч ирэхэд баярын хуралд оролцогчид алга нийжинүүлэн таниж халуун дотно угтав.

Баярын хуралд тус аймагт ажиллаж байгаа ЗХУ-ын мэргэжилтнүүдийн төлөөлөгчид орол-

цов. МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн баярын хуралд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч. Дашдэмбэрэл нээхэд хөгжимд БНМАУ, ЗСБН ХУ-ын төрийн дуулал эгшиглэв.

Баярын хурлын хүндэт тэргүүлэгчдээр нөхөр Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоог нэгэн дуугаар баяр байсгалантай алга нийжингэтэл таниж сонгов. МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн баярын хурлын илтгэлийг аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Адъяа тавихад хуралдагсад үе үе алга таниж байв. Баярын хуралд улсын анхдаугаар их хурлын тэргүүлэгч, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн гишүүн Балдан, Зөвлөлийн мэргэжилтэн А.И.Завалеев, Тээврийг удирдах газрын зам ашиглалтын хэлтсийн жолооч, V таван жилийн гавшгайч

Т.Сэмжаан, Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн саальчин, МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний малчин залуу» алтан медальт, илгээлтийн эзэн Г.Цэцэнбилэг, Зуунмод хотын 10 жилийн дунд сургуулийн багш Очирбат нар баяр хүргэж үг хэлэв.

Баярын хуралд аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн пионер сурагчид баярын илэрхийлэлт өргөлөө. Мөн хурал дээр түүхт 50 жилийн ойг угтаж зохиосон, аймгийн ХЗЭ-ийн гишүүд залуучуудын IV тойрон аялалын дунгийн тухай БНМАУ-ын Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний улсын хороо, МХЗЭ-ийн Төв Хороо, аймгийн Намын хороонд явуулсан рапортыг аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга П.Жанчив уншиж гардуулав. Баярын хурлын дараа Соёлын ордны жүжигчин, уран сайханчдын концерт тоглов.

Манай тэргүүлэгч Л.УНГААБУУ

Их ой, эрхэм хүндэт зочноо угтсан хөдөлмөрийн ээлжинд

БАТСҮМБЭРИЙНХНИЙ АМЖИЛТ

Батсүмбэр сум-САА н бүтээл хөдөлмөрчид их ой, Л.И.Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчдийн айлчлалыг угтаж социалист уралдааныг өрнүүлэн ажилласнаар сумын нэг өсгөх төлөвлөгөөг 104,5, нийгмийн малыг 117,3 хувиар биелүүлж улсад тушаах сүүний төлөвлөгөөг 50 хоногийн өмнө ханган, одоогийн байдлаар 200-гаад мянган литр сүү төлөвлөгөөнөөс илүү тушаагаад байна.

Энэ онд төмс, хүнсний ногооны ургац улсад тушаах төлөвлөгөөг 106,9 хувиар биелүүлсний дотор Пүрэв, Самбуу даргатай ногооны 1,2 дугаар бригад, Сэдэд, Шархүү даргатай саалийн 2,3 дугаар бригадууд бүсдаасаа давуу амжилт оллоо.

Ногоочин Даш, Кумсаа, Маан, саальчин Ц.Хорлоо, Тогтох, Думаа, тээвэрчин Бүрчиг, тракторчин Баз-

сандамба нарын 72 хүн V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 1 жил 6 сараас 7 сарын өмнө биелүүлж таван жилийн гавшгайч боллоо.

САА их ойн өмнө СХ-ийн байгууллага болох үүргээ биелүүлж аж ахуйгаараа СХ-ийн САА болсон амжилтаар их ойтойгоо золгож байна.

Сумын ХБ-ийн анги ном, бараа, нийтийн хоол борлуулах, талх барих эхний 3 улирлын төлөвлөгөөг 100—126 хувь, 5 төрлийн ноос бэлтгэх төлөвлөгөөг 100—140 хувиар биелүүлж IV улирлын төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө бүрэн биелүүлэх боломжтой болсны дээр бэлтгэлийн 52 нэр төрлийн зүйлийг 100—160 хувиар биелүүлээ. САА-н ажилчны клуб хөдөлмөрчид, тариачид, малчдын дунд зохиох соёл хүмүүжлийн ажил, кино гаргалтын орлого үзэгчдийн эхний 3 улирлын

төлөвлөгөөг 100—139 хувиар биелүүлээ.

Сумын хүний их эмчийн салбар амбулаторийн үзлэг, ор хоногийн болон урьдчилсан тарилга, эм борлуулах жилийн төлөвлөгөөнүүдийг 45 хоногийн өмнө 100—115 хувиар, харилцаа холбооны салбар орлого солилцооны жилийн төлөвлөгөөг 2 сарын өмнө 100,2 хувиар биелүүлээ. Мал өвөлжүүлэх бэлтгэлийг эртнээс ханган малыг отор нүүдлээр таргалуулах ажлыг зохиосноор нийт малын 84,9 хувь нь дунд ба дундаас дээш тарга хүчтэйгээр өвөлжиж байгаа бөгөөд бүх суурь, бригадын хашаа бүрэн засварлагдаж хэвтэр, бууц бэлдэх өвс тэжээл, бордоо 100 хувь өвөлжөөндөө татагдан ус, бэлчээрээр хангагдаж мал тарган өвөлжиж байна.

Г.ХААНХЯРВАА

МАХН-ЫН III ИХ ХУРАЛ ХУРАЛДСАНЫ БОЛОН
БНМАУ-ЫГ ТУНХАГЛАСНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

БНМАУ-ЫГ ТУНХАГЛАСАН НЬ

1924 онд феодалынгийн улс төрийн ноёрхлыг устгаж, ардын шинэ засаг төрийн байгууллагыг тогтоон бэхжүүлсэн нь монголын нийгэм улс төрийн байдал, ангуудын харилцаанд үндсэн өөрчлөлт гарав.

МАХН-ын Төв Хороо тус оронд Бүгд найрамдах маягийн засаглал тогтоохоор мөн оны 6 дугаар сарын 3-нд шийдвэрлэжээ.

Уг асуудлыг МАХН-ын III бүгд хурлаар 6 дугаар сарын 7-нд хэлэлцээд бүгд хурал «Одоо ардын эрхт улсын ёсонд нийцүүлэн Бүгд найрамдах засгийг явуулах тухай хэргийг хэлэлцээд Бүгд найрамдах ард улсын засгийг явуулбал зүйтэй болох ба Да Цэун гүн хэмээх их ерөнхий даргыг сонгохгүй, улсын дээд эрхийг улсын их хурлын дүрмийн ёсоор тус хуралд хадгалж хурлын чөлөө цагт засгийн газар хадгалах нь зүйтэй» гэж тогтоолдоо заажээ. МАХН-ын III их хурал 1924 оны 8 дугаар сард болж улс орноо капиталист биш замаар хөгжүүлэх зорилтыг МАХН-ын жанжин шугам болгон тавьж Ардын хувьсгалын хөтийн төлөвийг тодорхойлоод Ардын эрхт улсыг тунхаглахыг заасан билээ.

МАХН-ын III их хурал «Монгол улс бүх дэлхийн олон улстай адил харгис капиталан хөрөнгөтний дардал зовлонг үл амсан олон улсын одоогийн байдалд нийцүүлэн жинхэнэ ардын ёсыг баримтлан зоривол зүйтэй болов уу гэсэн тухайг хэлэлцээд эл илтгэсэн хэрэгт ийнхүү зорих нь зүйтэй бо-

лох учир бүгдээрээ зөвшөөрөн батлаж тогтов» гэжээ.

БНМАУ-ын анхдугаар их хурал 1924 оны 11 дүгээр сард нийслэл хүрээнд нээгдэв.

Улсын анхдугаар их хурал Ардын засгийн газраас явуулсан дотоод гадаад бодлогыг сайшаан ардын засгийн газраас тус улсын дотоодын байдал нь хэдийгээр үлэмж бүдүүдэг бөгөөд улсын аливаа хэргийг шийтгэхэд цаг тухайд нь нийцүүлэх зүйл үлэмж байсан боловч жинхэнэ ардын ёсны үндэс зорилт болгож өчүүхэн төдий хэлбийсэнгүй ямагт хичээн зүтгэсээр одоо улсын уг суртал байдалд тавтай нийлэлцэх ард түмний эрхт бүгд найрамдах улс төр байгуулсан ба бас гадаадтай харилцах явдлыг хянавал өөрийн ашиг тусыг хичээхгүй манай монгол улсад үнэн сэтгэлээр туслан тэтгэж улс төрийг бадруулах ба дэлхий дахины дорнод хязгаарт бүхий олон ядуу буурай улсыг туслах тэтгэхийг хичээх зөвлөлт засагт нийгэм журамт Бүгд найрамдах холбоот улстай найрамдлыг зузаатган харилцан туслацгай байгаа нь цөм маш зүйтэй» гэж заагаад улсын аливаа хэргийг жинхэнэ ардын ёсонд нийцүүлэн улмаар сайжруулан явуулахыг ардын засгийн газарт үүрэг болгожээ.

Анхдугаар их хурал хувьсгалын ялалт амжилтыг нэгтгэн дүгнэж хуульчлан бататгасан БНМАУ-ын анхдугаар үндсэн хуулийг баталжээ. Анхдугаар үндсэн хуульд: Монгол улсыг

үүнээс хойш Бүгд Найрамдах бүрэн эрхт Ард улс гэж улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэн улсын аливаа хэргийг улсын их хурал, мөн хурлаас сонгогдсон засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино» гэж заасан билээ.

БНМАУ-ын үндсэн хуульд «Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилт бол хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр нь устгаж улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийцүүлэн шинэ Бүгд Найрамдах улсын үндэс тулгуурыг бататган бэхжүүлнэ» гэж заагаад Ардын төрөөс явуулах гадаад бодлогын чиг шугамыг үндсэн хуульд «Бүх дэлхийн жинхэнэ ард түмний зорилго нь эдүгээгийн эзэрхэг хөрөнгөтний байдлыг үндсээр нь устгаж, нийгэм журамт ба эв хамтын ёс журмыг эрмэлзэх тул бидний жинхэнэ ард улсаас гадаад лугаа харилцах засгийн бодлогыг бүх дэлхийн бага буурай улс ба хувьсгалт ард түмний ашиг тус үндсэн зорилго лугаа нийцүүлэн явуулбаас зохимой» гэж анхич намч байр сууринаас тодорхойлжээ.

БНМАУ-ыг ийнхүү тунхагласан билээ.

Г. НЯМБУУ

ТООНЫ ХЭЛЭЭР

БНМАУ одоо дэлхийн 67 оронтой дипломат, 30 шахам оронтой соёлын, 20 гаруй оронтой эдийн засгийн харилцаатай байна. Мөн НҮБ болон олон улсын 60 гаруй байгуулгын гишүүн юм.

ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСАД



ЗУРАГ ДЭЭР: (баруун гараас) ЗСБНХУ-ын эмэгтэйчүүдийн шатрын шигшээ багийн тамирчин, олоо улсын мастер Н. Александрия, дэлхийн аварга Н. Гамринданили, мастер И. Левитина.

МОСКВАГИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖ

... Иван Павлович гэнэт муудаж зүрхний нь орчим хүчтэй өвдөн ухаан алдлаа. Гэвч Иван Павловичийн амийг Москвагийн түргэн тусламж аварлаа. Өвчин эхлэн хөдөлсөн ашинд нь өвчтөнг больниод хүргэж өгч чадахаар ажил нь зохион байгуулагдсан баталгаатай байдаг.

ЗХУ-д түргэн тусламжийн утасны дугаар аль ч хотод ижилхэн байдаг учир хаанаас ч дуудаж болно. Иван Павлович Курягинд тохиолдсон эвгүй явдлыг эхнэр нь «03» номерын утсаар Москвагийн түргэн тусламжийн станцтай ярьж хаягаа өгчээ. Станцын төв диспетчер тэр дор нь шинж тэмдгээр нь инфаркт гэж мэдээд нэг их эмч, хоёр бага эмч оролцсон «Дотрын өвчний шуурхай бригад»-ыг өвчтөн рүү явууллаа. Түргэн тусламжийн бичхан автобус нь зүрхний цахилгаан бичлэг, зохиомол амьсгалын аппа-

рат, нойрсуулах төхөөрөмж, зүрхний хэвийн ажиллагааг зохицуулах аппарат зэрэг өвчтөнд түргэн туслахад бүх зүйл нь зориулагдсан аж.

Дөрвөн минутын дараа бригад явахад бэлэнсэн дохио өгч, 11 минут болоод Курягинд очжээ. Очмогч энэ эмч урьдчилсан онош тавьж шаардлагатай тарилгыг хийж, туслагч нар нь өвчтөнг машинд орууллаа.

Ингээд 8 минутын дараа машин 4 дүгээр больниод ирснээ диспетчерийн газар радиотелефоноор мэдэгдсэн байна.

Түүнд минуттаар тооцоолон үйлчилж И. П. Курягны амьс нас аврагдсан юм. Өрнөдийн эмч нар ЗХУ-ын түргэн тусламжийн ажиллагаатай танилцаад сайн байна гэж нэгэн дуугаар хүлээн зөвшөөрчээ.

«Европын эмнэлгийн хамгийн сайны нэг нь (Төгсгөл нь VI нүүрт)

ХӨДӨЛМӨРЧДИЙН ЭРЭЛТ ХҮСЭЛТ

БНМАУ-ын үндсэн хуульд БНМАУ-ын иргэд, төрийн байгууллага ба албан тушаалтны хууль бус ажиллагаа, чирэгдэл, хүнд суртал гаргасан тухай төрийн эрх барих газар болоод захиргааны аль ч байгууллагад өргөдөл, гомдлоо амаар буюу бичгээр өгөх эрхтэй. Улсын байгууллага ба албан тушаалтнаас уул өргөдөл, гомдлыг дарагдуулахгүй хянан үзэж хариуг өгөх хэрэгтэй гэжээ.

Манай нам, засгаас хөдөлмөрчдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх журмын талаар тодорхой арга хэмжээ авч нарийн журмуудыг тогтоосон билээ.

Энэ талаарх журам зарчмыг улс хоршоолол, олон нийтийн байгууллагуудын удирдах харуцлагатнууд болон хөдөлмөрчид гүнз-

гий судлаж мэдсэн байх явдал чухал. Зарим хүмүүс энэ журам зарчмыг мэдэхгүйгээс өөрийгөө хохироох, удирдах албан тушаалтнууд хөдөлмөрчдийг чирэгдүүлж хүнд суртлын байдлаар хандах явдал үзэгддэг.

Баян-өнжүүл сумын «Хайрхан» нэгдлийн зөвлөл, нэгдлийн гишүүн Д. Гэндэнсүрэн, Х. Довчин, Д. Жамъян нарын гомдлыг 5 сар гаруй хугацаагаар дарагдуулаад одоо болтол шийдвэрлэж өгөөгүй байсан нь шалгалтаар илрэв.

Хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт, санал гомдлыг хянан шийдвэрлэх журмын хууль тогтоомжуудыг удирдах ажилтнууд судлаж мэдсэн байх ёстой.

Ард иргэд, ажилчин, албан хаагчдын санал, өргөдөл гомдлыг хянаж шийдвэрлэх үйл ажилла-

гаа нь хууль тогтоомж, нийгмийн болон иргэний хувийн эрх ашигт нийцсэн зүй ёсны эрэлт хүсэлтийг хэрэгжүүлэхэд бүрэн чиглэсэн байвал зохино.

Аливаа эрэлт хүсэлт, санал гомдолд маш анхааралтай хандах явдал чухал. МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал: «Манай улсын ба аж ахуйн байгууллагад хөдөлмөрчдийн гомдлыг цаг тухайд нь хянаж үздэггүй, ард түмний хэрэгцээ, эрэлт хүсэлтийг хянаж сайхнаар хүлээн авахгүй, харин үл ойлгох байдлаар үзэх явдлыг олон ажилтны зүгээс гаргаж байгаа нь хүнд суртлын илэрхий тодорхой хэлбэрийн нэг мөн.

Тийм ажилтан бол гом-

дол бүрийн цаана амьд хүн бий, хөдөлмөрчдийн захидалд олон чухал утга санаа агуулагдаж байгаа гэдгийг мартаж байсан гэж онцлон тэмдэглэснийг сум, хот, хороод, улс, хороо, олоо, олон нийтийн байгууллагууд, түүний ажилтан бүр хатуу санаж биелүүлэх хэрэгтэй.

Хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт, санал гомдол, мэдээлэл хичнээн өргөн олноор гарч байвал ажилд төдий чинээ ихээхэн ач холбогдолтой бөгөөд ажлын тасалдал, хүнд суртал хөшүүн хойрго ажиллагааг илрүүлэн засахад ашиг тусгаа өгөх болно.

Хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт, санал гомдлыг хянан шийдвэрлэх журмыг судлахдаа санал өргөдөл, гомдол, мэдээлэл гэж юуг хэлэх, иргэд санал өргөдөл гомдлоо гаргах, түүнийг хүлээн авах бүртгэх, шалгах, шийдвэрлэх, өргөдөл, санал гомдлыг хянан, хэдий ху-

гацаанд шийдвэрлэж хариу өгөх, хяналтыг хэрхэн тавих, иргэдийн санал гомдол, гомдлын тайлан мэдээ гаргах, мөн иргэдийн санал өргөдөл, гомдлыг саатуулж үргэдүүлэх, худал мэдүүлсэн хүмүүст хариуцлага хүлээлгэх зэргийг ялган ангилж, нарийвчлан үзэх хэрэгтэй.

Иргэдийн санал өргөдөл, гомдол бол нам, төр, олон түмний холбоогдох жүүлэх, төрийн хэрэгт ард иргэдээс идэвхтэй оролцох, нэгж салбар, олон түмний санал бодол хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэх чухал хэрэгсэл мөн учраас энэ асуудалд нам, улс, хороо, олоо, олон нийтийн байгууллагын удирдах албан тушаалтан болон иргэд бүр хариуцлагатай хандаж энэ талаар гарсан заавар журмыг хичээл семинараар буюу бие дааж сайтар судлах нь чухал юм.

Г. НЯМБУУ

Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

БНМАУ-ын иргэдийн үндсэн эрх, түүнийг хангах баталгаа

Манай улсын үндсэн хуулийн нэг чухал тал нь хөдөлмөрчдийн эрхийг албан ёсоор тунхаглаад зогсоогүй харин түүнийг хангах эд материалын баталгааг батлан заасанд оршино.

Тус улсын иргэдийн эрхийг хангах үндсэн хуулийн баталгааг улс төр, эдийн засаг, хууль цаазны гэж хуваана.

Улсын засгийн эрх ард түмний мэдэлд байж, ард түмний үйл ажиллагааг МАХН удирдаж байгаа нь иргэдийн ардчилсан эрхийг амьдралд хэрэгжүүлэхийн улс төрийн баталгаа болно.

Манай улсын социалист системийн аж ахуй нийгмийн социалист өмч нь иргэдийн үндсэн эрхийн эдийн засгийн баталгаа юм. Иргэдийн ардчилсан эрхийг хангах хууль цаазны баталгаа нь тэрхүү эрхийн тухай зөвхөн үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор батлагдсанаар хязгаарлах биш, тэдгээрийг хэрэгжүүлэх явдал төрийн бүх байгууллагын үүрэг байгаагаар илэрнэ. Манай улсын иргэд эрэгтэй, эмэгтэй, арьс, үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрх эд-

лэж түүний үндсэн дээр нийгэм, улс төрийн амьдрал, аж ахуй, соёлын бүх салбарт тэгш оролцдог юм. БНМАУ-ын иргэн бүр аж ахуй-соёлын байгуулалтын аль ч салбарт хүч чадал мэдлэгээ саадгүй ашиглан, хөдөлмөрлөж, хийсэн хөдөлмөртөө тохирсон цалин хөлс авч хөдөлмөрлөх эрхээ эдлэх бололцоог тус улсын социалист аж ахуйн системийн бүх давуу тал хангач байна.

Манай үйлдвэрийн ажилтан, ажилчид, ХАА-н нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийн нь цалин хөлсийг тэдгээрийн ажлын гүйцэтгэл болон хэмжээ чанарт тохирсноор олгож байгаа нь иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаж байгаа баталгаа юм.

Иргэд нийгмийн үйл хэрэгт идэвхтэй оролцох үр бүтээлтэй хөдөлмөрлөхийн тулд эрүүл энх хөдөлмөрлөх бүрэн чадавхтай байх нөхцөлийг амар эрх эдлэж байгаагаар олж авна.

Тус улсад ажлын өдрийн дээд хэмжээг 8 цагаар тогтоож, зарим онцгой мэргэжлийн ажлын цагийг хорогдуулж, ажилчин албан хаагчдыг долоо хоног бүрийн ням

гариг, жил тутам ээлжийн амралтаар амруулж цалинг хэвээр олгож, баяр ёслолын болон 7 хоногийн ням гаригийн урьд өдөр 6 цаг ажиллуулж, мөн баяр ёслолын өдөр амруулдаг.

Амралтаа зөв боловсон үр ашгтай өнгөрүүлэхэд зориулан улсаас амралт, рашаан сувиллын газар, театр, клуб, цирк, кино, номын сан, музей, биенийн тамир спортын зэрэг үйлчилгээний газрыг хөдөлмөрдөд зориулан ажиллуулж энэхүү эрхийг хангадаг. Иргэд нас хөгшрөх, мөн өвчлөх, хөдөлмөрийн чадвар алдах, тэжээгчээ алдахад эдийн тусламж авах эрхтэй.

Нийгмийн даатгал, улсын тэтгэвэр, хоршооллын байгууллагын тусгай фондын системээр дамжуулан хөдөлмөрдөд тусламж олгож, амралт сувиллын газрыг олшруулсан, эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлж хөдөлмөр хамгаалж хэрэгжүүлж энэхүү эрхийг хангана.

Иргэдийн сурч боловсрох эрх нь тэдний үндсэн эрхийн нэг бөгөөд үнэ төлбөргүй сургаж, ерөнхий боловсролын боломж техник мэргэжлийн сургууль, тусгай мэргэжлийн дунд сургууль, дээд сургуулийг олшруулж мэргэжил дээшлүүлэх явдлыг хөгжүүлэн тусгай мэргэжлийн дунд ба дээд сургуулийн буюутнуудад улсаас цалин олгож энэ эрхийг хангадаг.

Тус улсын иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан улс ба нийгэм, аж ахуйг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй.

Энэ эрхийг тус орны улс төр, аж ахуй, соёлын байгууллагын бүх салаа мөчирт өргөнөөр оролцох, үүний дотор сонгууль ард түмний санал хураахад оролцох, төрөл бүрийн ардчилсан нийгэмлэг байгуулах бодит бололцоог бүх иргэдэд олгосноор хангана.

Түүнчлэн хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллага үйлдвэрчний эвлэл, хоршоолол, залуучууд, биенийн тамир спортын эвлэл зэрэг байгууллага, соёл шинжлэх ухаан техникийн нийгэмлэг, улс түмний найрамдал, энх тайвныг бэхжүүлэх нийгэмлэг зэрэг олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх эдлэнэ.

Социалист төрийн байгууллагыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн тус улсын иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг үндсэн хуулиар олгожээ.

Тус орны төв, хөдөөд явагддаг янз бүрийн хурал, цуглаан зөвлөглөөн, жагсаал ёслол зэрэг нь ард түмний эх оронч үзэл бодол болон нам, засагтаа халуун хайртай, энх тайвны үйл хэрэгт дургүй болохыг илэрхийлдэг юм. Иргэдийн хувийн эрх чөлөө биенийн халдашгүй

байдал нь тэдний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдарт хэнч халдаа буюу хор хургээ болохгүйг хуулиар тогтоосон байдаг.

Тус улсын иргэдийг хууль бусаар баривчлах, эрх чөлөөг эвдэх, биений эрүүл мэндэд хохирол учруулах, нэр алдрыг доромжлох явдлыг үндсэн хууль болон бусад хуулиар хориглосон байна.

Мөн иргэдийн орон сууцны амгалан байдал, захидал харилцааны нууц нь халдашгүй эрхээр хангагджээ.

Иргэд өөрсдийн хөдөлмөрлөж олсон орлого, хадгаламж, орон сууцны туслах аж ахуй, хэрэгцээт зүйл, гэрийн эд хогшлыг аминдаа эзэмших эрхтэй.

Тус улсын иргэд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаа, чирэгдэл, хүнд суртал гаргасан тухай төрийн эрх барих байгууллага болон захиргааны аль ч байгууллагад өргөдөл, гомдлоо амаар буюу бичгээр өгөх эрхтэй. Улсын байгууллага албан тушаалтнаас уул өргөдөл гомдлыг дарагдуулалгүй хянах үзэж хууль ёс зөрчсөн явдалд арга хэмжээ авч өргөдөл гомдлын хариуг өгөх үүрэгтэй байдаг.

Манай орны хөдөлмөрчид ийм ардчилсан эрх чөлөө эдлэж байгаа нь МАХН-ын улс төрийн бодлогын жинхэнэ биелэлийн баталгаа юм.

Г. ШАРАВ

Албан тушаалын гэмт хэргийн тухай

Улс хоршоолол, олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд социалист хууль ёсыг нарийн чанд сахин биелүүлж төрийн болон аж ахуйн байгууллагын ажиллагааг байнга боловсронгуй болгон сайжруулахад албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал чухал аж холбогдолтой юм.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 119 дүгээр зарлигаар албан тушаалын гэмт хэргийн тухай БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 135, 136, 137 дугаар зүйлүүдийг дор дурьдсанаар өөрчлөн найруулсан байна.

136 дугаар зүйл. Албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглах хэргүүд

Албан тушаалтан өөрийн албан тушаалын байдлыг санаатайгаар албан ажлын сонирхолд харш ашиглах, түүнийг хуулиар олгосон эрх хэмжээнээс илгэд хэтэрсэн явдлуудыг үйлдсэн нь улс нийгмийн ашиг сонирхол, өмч хөрөнгө, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бага

бус хор хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.

Энэ гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэсэн, хорьсон, бусдыг доромжилсон буюу их хэмжээний хохирол буюу ноцтой хор аюул учруулсан, эсхүл албан тушаалын гэмт хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд үйлдсэн бол 3-10 жил хүртэл хугацаагаар хорьж тодорхой албан тушаал эрхлэхийг 2-5 жил хүртэл хугацаагаар хориглоно.

137 дугаар зүйл. Албан үүргээ биелүүлэхгүй байх буюу хариуцлагатай хандах

Албан тушаалтан өөрийн үүрэгт ажилдаа цагаар назагй хариуцлагатай хандсаны улмаас өөрийн албан тушаалын үүргийг биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлэхгүйгээс улс нийгмийн ашиг сонирхол, өмч хөрөнгө, иргэдийн хууль ёсны ашиг сонирхолд ба-

га бус хор хохирол учруулбал 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.

Албан тушаалын гэмт хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд энэ гэмт хэргийг үйлдсэн, эсхүл их хэмжээний хохирол ноцтой хор аюул учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 2-7 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ гэжээ.

Албан тушаалын гэмт хэрэг бол улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын албан тушаалтнуудаас өөртөө хуулиар олгогдсон эрх хэмжээг ашиглан уг байгууллагын хэвийн ажиллагаа нэр хүндэд халдаж, улс нийгэм, иргэдийн ашиг сонирхолд хор учруулсан байдагт түүний нийгмийн хор аюул нь оршино.

Албан тушаалын гэмт хэргийг үйлдэгч(субъект) нь зөвхөн улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад ажилладаг албан тушаалтан хүн байна. Энэ бол үндсэн ойлголт юм.

(Төгсгөл нь IV нүүрт)

ОТРЫН ГЭРТ ХИЙСЭН ХУРИМ

Заамар сумын төвөөс урагш 10 гаруй км орших өндөр хөх уулыг Цавын хангай гэнэ.

Цав хангайн оргил битүү буданд хучигдан уулын бэлнийг цас бүрхсэн нь өглөөний наранд мөнгө адил цавцайн харагдана. Цав хангайн урьд байгаа жижиг гэрийн яндангаар утаа алгуурхан суунаглаж гадаа нь малын хэвтэр бараантан байв. Айлын гэрээс урагш тав зургаан зуугаад хонин сүрэг налайн бэлчээр лэж, хүрэн дээлтэй хүн морио хөтлөж хонио тогтоож явлаа.

Бидэнтэй хамт явсан нэгдлийн ерөнхий зоотехник Батсүх — Энэ айл өчигдөр шинэ гэр байдгаар хурим хийгээд байгаа. Д. Банзрагчийнх гэдэг айлдаа.

Бид Банзрагчтай уулзав. 20 орчим насны тэр залуу: Цэргийн алба хааж нутагтаа ирж 3 сар адуу маллаад одоо өөрийнхөө хүсэлтээр бод малын бригадаас «Ундарган» брига-

дын хоньчин болох гэж хурганы суурь хариуцан агаад байгаа минь энэдээ. Нэгдлийн зөвлөл налад отрын гэр, тавилгын хамт өглөө.

Ингээд нутгийн охин Должинтой гэр бүл болж өчигдөр хуримаа хийлээ.

Манайд очигцоогой гэлээ. Тэр, хариуцан малдаж буй хургаа цас бага байвал Хоньч, Эрэн хавирга, Тосон бүрдийн нуруугаар өвсний сайхныг дагуулан олон нүүдэл хийж өвөлжүүлнэ.

Хэрэв цастай болбол Заамарын өвөр дэх хаашаандаа бууна гэж ярих.

Түүний гэргий Должин мөн л Банзрагчийн нэгэн адил санаа өвөрлөж 600 хургаа онд тарган оруулах тухай өгүүлж байв.

Отрын бэлчээрт, Отрын гэрт хурим хийж хурганы суурь хүлээн авч хариуцж байгаа МХЗЭ-ийн гишүүн энэ хоёр залуу сэтгэл зүтгэл нь нэг болохоор үйлс ажил нь бүтэмжтэй байна.

Ш. БЯМБАА

Албан тушаалын гэмт хэргийн тухай

Төгсгөл. (Түрүүч нь
III нүүрт)

Харин албан тушаалтан бус ч гэсэн уг хэргийг зохион байгуулагч, хамтран хамжигч зэрэг аль нэг хэлбэрээр оролцогчид албан тушаалын хэрэгт хамтран шийтгэгдэж болно.

Албан тушаалтанд орон тооны бус буюу мэргэжлийн хүн ч тооцогдож болно.

Энэ нь захирамжлах, зохион байгуулах, захиргаа аж ахуйн албан үүрэгтэй шууд холбоотой нөхцлөөс шалтгаална.

Жишээ нь: Хууль дүрэм буюу эрх бүхий байгууллагаас гаргасан эрхийн актын үндсэн дээр бараа материал, үнэт зүйлийн тооллогын комиссийн, сургуулийн элсэлт шалгалтын комиссын гишүүн зэрэг захирамжлах, зохион байгуулах буюу захиргаа аж ахуйн албан үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүс холбогдож болохын гадна засгийн төлөөлөгч албан тушаалтанд тооцогдоно.

Ийм учраас албан тушаалтны тухай ойлголтыг БНМАУ-ын эрүүгийн хуулийн 135 дугаар зүйлд улс хоршоолол олон нийтийн байгууллагад захирамжлах, зохион байгуу-

лах буюу захиргаа, аж ахуйн албан үүргийг байнга буюу түр, эсвэл дээр дурьдсан үүргийг мэргэжлийн буюу тусгайлан олгосон эрх хэмжээний дагуу гүйцэтгэж байгаа хүмүүс болон засгийн төлөөлөгчийг албан тушаалтан гэж үзнэ гэж заажээ.

Тэгвэл захирамжлах зохион байгуулах албан үүрэг гэдэгт уг этгээд албан ажлын хувьд хууль тогтоомжоор олгосон эрх үүргийн дагуу бүх нийтэд буюу нийгмийн амьдралын тодорхой салбар нэгжийн гишүүдийн ахуй амьдрал, хөдөлмөрийн зохион байгуулалт, тогтоосон ёс журмыг биелүүлэх, үйлдвэрлэлийн болон төлөвлөгөөт даалгаврын биелэлтийг хангах асуудлыг хариуцан зохицуулж өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалтанд хяналт тавих үүрэгтэй бөгөөд шаардлагатай үед уг асуудлаа шийдвэрлэхийн тулд эрхийн хэм хэмжээг хэрэглэх буюу эсхүл хууль тогтоомжийн биелэлтэнд шууд хяналт тавих зэрэг эрхтэй байх явдал хамаарна.

Захиргаа, аж ахуйн албан үүрэг гэдэгт уг этгээд албан тушаалаар олгогдсон эрх үүргийн хувьд улс, хоршоолол,

олон нийтийн тодорхой байгууллага буюу түүний хэсэг салбаруудын захиргааны болон үйлдвэрийн үйл ажиллагааг шууд гардан удирдаж боловсон хүчнийг сонгон авах хуваарилах, тухайн байгууллагын улс нийгмийн өмнө хүлээсэн төлөвлөгөөт даалгаврын биелэлтийг хангах, хүмүүсийн хөдөлмөрийн бүтээл, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх асуудлыг эрхлэж байгаа буюу тухайн байгууллагад эзэмшиж байгаа социалист өмчийн эд хөрөнгийн хөдөлгөөн зарцуулалтыг шийдвэрлэж түүний байдалд байнгын хяналт тавьж байх зэрэг эрх үүргийг хамааруулан ойлгоно. Албан тушаалтны гэмт хэргийн үйлдэл нь

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлд зааснаар албан тушаалтан хаа байдлыг урвуулан ашиглах, хэтрүүлэх, мөн хуулийн 137 дугаар зүйлд зааснаар албан үүргээ биелүүлэхгүй байх буюу хариуцлагагүй хандах гэсэн хоёр төрлийн үндсэн үйлдэл хамаарагдаж байна. Албан тушаалын гэмт хэрэгт дурьдагдаж байгаа бага биш хохирол гэдэгт мөнгөн хэлбэрт оруулснаар 2000-10000 төгрөг их хэмжээний хохирол 10000-аас дээш төгрөгийн хохирол тус тус хамаарагдах бөгөөд харин ноцтой хохирол учруулсан гэдэгт уг гэмт хэргийн уршгаар албан байгууллагын хэвийн ажиллагаа нэр хүнд, иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул учрах зэрэг төгсгөлтэй хор аюул хамаарагдах жишээтэй юм.

О. ЛХАМСҮРЭН

Өнтэй өвөлжиж байна

Намар эрт орсон цас хайлж уулсынхаа оргилор хярмаг төдийцэстэй энгэр бэл нь намраараа шаргалтан, хөглөрсөн өтөг буутай өвөлжөө хондод халуу дүүгэж, хүн мал хоёр сэтгэл тэнгэр тааваараа байна.

Хэзэний цуутай Хэрлэн-баян улааны салбар уулс, энгэр бэлээр нь тү

мэн сүрэг налайж, малчдын гэрээс харганын цэнхэр утаа суунаглана.

Бугын уул, Зүрхийн бэлээр Архустын ТАА-н хоньчин Бямбажав, Нацаг, Дэжид, Муубарах, Дэмчиг нарын суурь 800-1000 хоньтой отрын соргог нутагт тавтай сайхан өвөлжиж байна.

Д. ОТГОН

Эмнэг хангалын

333Н

Баянжаргалан сумын малчин, МХЗЭ-ийн гишүүн Н. Дагвадорж бүх ард түмний социалист уралдааны жил-1974 онд эмнэг морь, тэмээг уналга эдэлгээнд сургах талаар амжилтанд хүрч байна.

Н. Дагвадорж эмнэгийг аль болох бага насанд нь сургахыг голчлодгийн гадна эмнэг сургахад тохирсон эмээл, хазаар, чөдөр, ногт зэрэг бүх хэрэглэлийг сайн бэлтгэж, эмнэгийг барьж аван урьдаар хөтлөж зүгшрүүлэн, эвээр илж таалах зэргээр биедээ дагдаж газрын уужим, тэгш талбайд унаж эхлээд яаралгүй хөдөлгөн явуулж дараа нь шогшуулах, хатруулах, зөөлөн давхих зэргээр амьсгааг нь задлаж сургадаг байна.

Н. Дагвадорж 1974 оны эхний хагас жилд 52 эмнэг сургаж хөдөөгийн залуучуудын спартакиадад шалгарч хүрэл медаль авсаны дээр түүхт ойнуудыг угтаж 68 эмнэг морь, 2 тэмээ сургаж аймгийн ХЗЭ-ийн хороо, ХТ АЗ-ний зөвлөл, АДХ-ын чиг нарын суурь 800-1000 хүүхэд залуучуудын байнгын комиссоос зарласан болзолт уралдаанд шалгарлаа.

Л. ЭРХЭМБАЯР

Бүтээгдэхүүний чанар, үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулъя

(Аймгийн УЭ-ийн зөвлөлийн II бүгд хурал)

Аймгийн УЭ-ийн зөвлөлийн II бүгд хурал саяхан болж «Бүтээгдэхүүний чанар, үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах тухай» НАА УГ-ын дарга М. Нацагдорж, Баянцогтын САА-н дарга Чойжилжав нарын илтгэлийг хэлэлцэв.

Тавьсан илтгэл, уг хэлсэн хүмүүсийн ярианаас үзэхэд үйлдвэрлэл техникийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх талаар Баянцогтын САА, НАА УГ-ын захиргаа, УЭ-ийн хороо, зөвлөлөөс социалист уралдааныг өрнүүлж, үйлдвэрлэлд нөлөөлөх үйл ажиллагааг дээшлүүлэн, хөдөлмөр зохион байгуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, явцуу дамжлагыг арилгах, дотоод нөөцийг илрүүлэн ашиглах, үргүй зардалыг багасгах, машин техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлын ашиглалт, ажлын цагийн нягтралт, бүтээгдэхүүний чанарт захиргаа, олон нийтийн үзлэг шалгалт явуулах зэргээр нилээд ажил зохиож иржээ.

Гэвч тус хоёр газар, үйлдвэрлэлийн хүчин чадлыг ашиглалтыг МАХН-ын Төв Хороо, МҮЭ-ийн

Төв Зөвлөлийн V бүгд хурлын заалтын хэмжээнд хүртэл бүрэн сайжруулж нэгж бэлэн бүтээгдэхүүнд зарцуулах түүхий эд материал, түлш цахилгаан, эрчим хүчийг багасган хөдөлмөрдийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах явдал хангалтгүй байна.

Баянцогтын САА—д тракторын хүчин чадлын ашиглалт, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн фондын ашиглалт муу байна.

Эдгээр дутагдлын үндсэн шалтгаан нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн хүчин чадлыг дутуу ашиглаж, бүтээгдэхүүний чанарт нөлөөлөх дөвшилт арга барил нэвтрүүлэх талаар хангалтгүй анхаарч байгаа явдал гэж бүгд хурал зээд үйлдвэрлэлийг зохион байгуулах үйл ажиллагаанд ажилчид, инженер, техникчдийг өргөн оролцуулж үйлдвэрлэлийн явцад тавих хяналтыг одоогийн шаардлаганд хүртэл сайжруулах нь чухал гэж заав.

Мөн дотоод нөөцийг бүрэн ашиглах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гар

ажиллагаатай хүнд хүчир дамжлагыг механикжуулах, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмолжуулан сул зогсолтыг арилгах, бүх техникийг ашиглалтанд оруулах замаар үйлдвэрлэлийн фонд өгөмжийг нэмэгдүүлэх, ажилчдаар хэд хэдэн жилийн тооцоотой үүрэг авахуулах, инженер техникийн ажилчдаар хувийн бүтээлч төлөвлөгөө зохиолгох, ажлын уялдаа холбоотой үйлдвэрлэлийн нэгж хүмүүсийг уралдааны гэрээтэй ажиллуулах, үйлдвэр үйлчилгээний нийт газруудаар угтвар төлөвлөгөө зохиолгож, тэдгээрийн явц биелэлтийг богино хугацаанд дүгнэж байх, ХАА-н үйлдвэрлэлд салааны систем, хэсгийн зохион байгуулалт, барилгад аж ахуйн тооцоотой нэгдсэн бригад, авто тээвэрт сэлтийн бригад, худалдаанд хамтын тооцоотой бригад, нийт үйлдвэр аж ахуйн газарт согоггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх Сараторын системийн ажлын туршлагыг нэвтрүүлэх, шинжлэх ухааны үндэстэй хөдөлмөр зохион байгуулалтыг үйлдвэр үйлчилгээний газруудад тууштай нэвтрүүлэх зорилгоор УЭ-ийн хороо

зөвлөлийн дэргэд инженер, техникчдийн бүтээлч нэгдлийг байгуулан ажиллуулах нь зүйтэй гэж бүгд хурал үзлээ.

Төрчлөн үйлдвэрийн зохион байгуулалт соёлч шуурхай үйлчилгээг хангах, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн явцуу дамжлагыг арилгах, шинэ санаачлага тэргүүн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр сэдэвт уралдааныг өрнүүлэх, СХ-ийн хамт олны авах үүргийг ил бүрэн төлөвлөгөөтэй болгож биелүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд улирал бүр үзлэг явуулж дүгнэх.

Аймгийн «Анхдугаар таван жил» сонин СХ-ийн үйлдвэрийн туршлагаар чанарын талон хэрэглэж ажилчид, мастер чанар шалгагчийн ажилд үнэлэлт өгч чанарын анхан шатны бүртгэл судалгааг нарийн тооцоотой явуулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан согоггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех, тасаг, ээлж, бригад, ажилчдыг шалгаруулах хөдөлгөөн өрнүүлэх.

Бүтээгдэхүүний чанарын өдөрлөгийг удирдтатм явуулж үйлдвэрлэлийн чанарын аваргыг

шалгаруулдаг болох нь зүйтэй.

Мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт тэргүүний арга барилыг тууштай нэвтрүүлэх, бүтээгдэхүүнийг шалгаруулах уралдаан зарлах, шалгарсан бүтээгдэхүүнээр жил бүр үзэсгэлэн ажиллуулах.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэн чанарыг сайжруулахын тул агротехникийн шаардлагыг хангах арга хэмжээний их бүрэн төлөвлөгөөтэй ажиллах.

Үйлдвэрлэлийн нэгж цех, тасаг, бригадын дарга, мастер нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилчдын мэдлэг мэргэжил, ажлын дадлага, тогтвор суурьшилыг сайжруулахад үйлдвэрлэлийн захиргаа, УЭ-ийн байгууллагаас системтэй арга хэмжээ авах.

Ажилчдын ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг дээшлүүлж, ажлын цагийн нягтралыг сайжруулахын хамт техник төхөөрөмжийн засварт байх хугацааг багасгах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой амжилтанд хүрэхийн чухлыг бүгд хурал онцлон заав.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТ ОЛНЫ ХҮМҮҮЖИЛ

Саяхан МҮЭ-ийн Төв зөвлөлийн соёл олон түмний хэлтэс, аймгийн ҮЭ-ийн зөвлөлөөс эрхлэн «Хөдөлмөрийн хамт олныг хүмүүжүүлэхэд ҮЭ-ийн байгууллагын роль» гэсэн сэдвээр онол практикийн бага хурал хийлгэв. Бага хуралд «Хөдөлмөрийн хамт олныг хүмүүжүүлэхэд ҮЭ-ийн байгууллагын роль» гэсэн илтгэлийг МҮЭ-ийн Төв Зөвлөлийн соёл олон түмний хэлтсийн ажилтан Цэрэндаш, «Хөдөлмөрийн хамт олны хүмүүжлийн талаар зохиож байгаа ажил, зорилт» гэсэн илтгэлийг аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн нарийн бичгийн дарга П. Очирбат нар тус тус тавьж хэлэлцүүлэв.

Тавьсан илтгэлүүдтэй хол богдуулж Жаргалантын САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Н. Дашням, ТУГ-ын зам ашиглахтын хэлтсийн дарга Г. Лувсанчултэм, Батсүмбэрийн САА-н ногооны бригадын дарга Ж. Пүрэвзаймгийн прокурор, БНМАУ-ын гавьяат хуульч О. Лхамсүрэн, Хүнсний үйлдвэрийн дарга С. Цэгмид, НААҮГ-ын хивсэн тасгийн мастер Жамсран, улсын хөдөлмөр тэтгэмжийн газрын дарга Зинээмидэр, аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтсийн дарга Ц. Дэлхсүрэн, аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтсийн эрхлэгч Я. Дамдинсүрэн нар үг хэлэв.

Хөдөлмөрийн хамт олны хүмүүжлийг дээшлүүлэх үндсэн нөхцөл бол соёл ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх явдал мөн. Жаргалант, Батсүмбэр, Борнуурын САА, Хүнсний үйлдвэр, НААҮГ-ын нам захиргааны байгууллагууд ажилчны клуб, улаан булангийн тохижилт соёлжилтыг сайжруулах, урлаг уран сайханчдын эгнээг өргөтгөх, биеийн тамир спортыг хөгжүүлэх, хөдөлмөрийн хамт олны авъяас чадварыг нэмэгдүүлэхэд нилээд анхаарч байна.

Түүнчлэн ажилчдын орон сууц, цэцэрлэг яслын барих, биеийн тамирын заал, талбай байгуулах ажил хийжээ.

Клуб улаан булан бол хөдөлмөрийн хамт олны соёл хүмүүжлийн төв байх ёстой.

Эндээс төлөвлөгөөтэйгөөр соёл хүмүүжлийн олон ажил зохиож, төрөл бүрийн секц дугуйлан ажиллуулж байгаа нь хамт олны хүмүүжил, соёлын түвшинд зохих нөлөөг үзүүлж байна.

СХ-ийн хөдөлгөөн, сургууль зэрэг нь хамт олныг хүмүүжүүлэх гол уурхай билээ.

Аймгийн нийт ажилчдын хоёр хүний нэг нь социалист хөдөлмөрийн хө-

дөлгөөнд хамрагдаж, СХ-ийн хамт олон болох байнгын жилд СХ-ийн 93 сургууль хичээллэж 100 хувийн сурлагын амжилт үзүүлэв.

Хамт олныг хүмүүжүүлэхэд тэдний хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх явдал чухал ач холбогдолтой. Аймгийн ҮЭ-ийн зөвлөл, хуулийн байгууллагуудтай хамтран ажилчин албан хаагчдад хууль дүрмийн талаар хичээл зааж шалгалт шүүлэг авах, онол практикийн болон гэгээрлийн хурал, төрөлжсөн зөвлөгөөн хийж хууль зүй гэмт хэргээр зөрчилгүй хамт олны туршлага, социалист уралдааны явц дүн зэргийг радио нэвтрүүлэг хурал цуглаанаар сурталчилж байгаа нь хамт олны хүмүүжилд зохих нөлөө үзүүлж байна.

Аймгийн ХЗЭ-ийн хо-

хамт олны гол асуудлыг шийдвэрлэхэд олон түмнийг идэвхтэй өргөн оролцуулах нь хамт олны хүмүүжүүлэх ролийг дээшлүүлэх нэг хүчин зүйл болохыг тэргүүний хүмүүсийн туршлага харуулж байна.

Батсүмбэрийн САА-н ногоо бригадын дарга Пүрэвзаймгийн бүхнийг хамт олны хурал зөвлөгөөнөөр хэлэлцэн тэдний санал хүсэлтийг авч түүнийг тусгасан төлөвлөгөө зохион ажилладаг нь үр дүнд хүрч улсаас өгсөн төлөвлөгөө даалгавар нь жил дараалан давж биелэгддэг байна.

Мөн бригадын ажлын амжилт дутагдлыг өдөрт нь ажилчдад мэдэгдэж, хувь хүний гаргасан дутагдлыг хамт олноор нь хэлэлцүүлэн тэр хүнд хамт олноор буруугийн нь хүлээлгүүлдэг нь хамт олны хүмүүжүүлэх нөлөөг дээшлүүлэхэд үр дүнтэй болдог байна.

Тус үйлдвэрт чанарын талон хэрэглэснээр ажилчдын цагийн нягтрал, хөдөлмөрийн сахилга бат сайжирчээ.

Тус аймгийн хэмжээгээр V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жил хагасын хугацаанд БНМ АУ-ын баатар 1, хөдөлмөрийн баатар 9, гавьяат цолтон 5, улсын аварга малчин, тракторч комбайнч, ногоочин зэрэг улс, аймаг, сумын аварга сайчууд олон зуу төрөн гарлаа. Зөвхөн 1973 онд 324 хүн олон медаль төрийн дээд шагналаар шагнагдаж, 110 хүн улсын аварга цол хүртэж, 38 хамт олон социалист уралдаанд улсад шалгарч өндөр шагнал хүртэв.

Энэ бүхэн бол хөдөлмөр хүнийг хичээн их алдаршуулдгийн тодорхой баримт мөн.

Социалист уралдаан бол хөдөлмөрийн хамт олны соёл техникийн боловсролыг дээшлүүлж

байгаа нийгмийн баялгийн хэмжээ нь үйлдвэрлэлийн болон нийгэм улс төрийн амьдралд хөдөлмөрийн хамт олны оруулж байгаа амжилтаас ихээхэн шалтгаална гэдгийг сайн ойлгож хамт олны нэр хүнд олон түмний дунд хичнээн өндөр байх тутам тэр хамт олон хүмүүжүүлэх үүргээ төдий чинээ сайн биелүүлж чадна.

Иймд юуны өмнө хүн бүхэн хамт олныхоо амжилтаар бахархаж дутагдал гаргахад нь сэтгэл зовж засан хүмүүжүүлдэг байх ёстой.

Хамт олны хөдөлмөрийн амжилт, төлөвлөгөөний болон уралдааны үүргийн биелэлтийг тогтмол шуурхай мэдээлж байх нь чухал ач холбогдолтой юм.

Биеийн тамир спорт урлагийн үзлэг тэмцэнд хамт олноор нь идэвхтэй оролцуулах, ажилчдын чөлөө цагаар явуулах соёл хүмүүжлийн ажлын программыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж тодорхой хэлбэрийн ажлыг тогтмол явуулж заншвал зохино.

Үйлдвэрлэлийг удирдах хамт олны гол асуудлыг шийдвэрлэхэд олон түмнийг идэвхтэй оролцуулах гол хэлбэр болсон ажилчдын хурал үйлдвэрлэлийн байнгын зөвлөгөөний ролийг өндөржүүлэх нь чухал.

Чанарын талон хэрэглэн бүтээгдэхүүнийг голдлыг багасгаж үйлдвэрлэлийн аварга тэргүүний хүмүүсийг шалгаруулан гадаад амруулж байгаа аймгийн «Анхдугаар таван жил» сонин, сүүлийн 10 жилд гэмт хэргээр эерчилж гараагүй байгууллагаараа гэмт хэргээр эерчилгүй хамт олон болсон аймгийн Хүнсний үйлдвэрийн туршлагыг нийтэд дэлгэрүүлэх хэрэгтэй.

Байгууллага бүхэн хэлтийн зорилттойгоор хамт олны коммунист ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэн бүрэлдүүлэхэд онцгой анхаарч ажиллах явдал чухал байна.

Л. ГУНГААБУУ

ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ

роотой хамтран коммунист хүмүүжлийн сургууль, хөдөлмөрийн алдартмдэгдэх, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хөдөлмөрийн баатар, тэргүүний сайчуудтай уулзах, чуулга уулзалт хийж байгууллагын оны аварга шалгаруулах аялал экскурс, тэмцээн зохиож ирвэ. Эдгээр ажлын дүнд хөдөлмөрийн хамт олны хүмүүжлийн агуулга хэлбэр баяжиж үр нөлөө нь дээшлэн тэргүүний хамт олон олшров.

Аймгийн Хүнсний үйлдвэрийн захиргаа, ҮЭ-ийн хороо, хөдөлмөрийн алдрын танхим байгуулж, түүндээ шинээр ажилд орогчдыг хүлээн авч, үйлдвэрлэлийнхээ түүхэн замнал, хамт олны хувьсгал, хөдөлмөрч уламжлалаас таниулж, ажилчдын үнэмлэх, анхны цалингардуулах баяр ёслол тэмдэглэх, үдэшлэг уулзалт хийж алдаршуулах олон хэлбэрийн ажил зохиож байгаа нь үр дүнгээ өгчээ. Борнуурын САА-н захиргаа, ҮЭ-ийн зөвлөл сургууль төгсөөд ХАА-д ажиллахаар ирсэн хөвгүүд охидыг зөвлөлийн тэргүүлэгчид, САА-н удирдах хүмүүс БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, тэргүүний сайчуудын төлөөлөгчид хүлээн авч САА-н хөгжил ахмад сайчуудын туршлагаас ярьж, тэргүүний хүмүүсээр зөвлөгөө өгүүлэх, ажиллах бригадалд нь баяр ёслолын байдалтай хүлээн авахуулж, хөдөлмөрийн багаж, саалийн хувин, адууны уурга хуйв, бурад машин төхөөрөмжийг хүлээлгэн өгдөг нь ач холбогдолтой юм.

Үйлдвэрлэлийг удирдах,

Аймгийн тээврийг удирдах газрын замын ангийн хэлтэс тэргүүний хүнийг алдаршуулахдаа түүнийг гэр бүл үр хүүхэд төрөл садангийн хүнийг урьж ирүүлэн тэд нарт баяр хүргэн дурсгалын зүйл гардуулдаг нь хамт олныг хүмүүжүүлэхэд ач холбогдлоо өгч байна.

Эдгээр ажлын дүнд зам ангийн хамт олон V таван жилийн төлөвлөгөөг жил гаруйн өмнө биелүүлж, СХ-ийн хамт олон болжээ. Аймгийн Намын хороо, АДХ-д захиргааны «Анхдугаар таван жил» сонин СХ-ийн үйлдвэр чанарын талонг улсад анх удаа хэрэглэж, ЗХУ болон бусад ач дүү социалист орнуудад уралдаанд шалгарсан ажилчдыг ариуулах, аялал экскурс явуулах ажил зохиосон нь хамт олны хүмүүжилд сайн нөлөө үзүүлж гэмт хэргээр зөрчилгүй хамт олон болох нөхцлийг бүрдүүлжээ.

СҮҮЛЧИЙН ШУУДАНГААР

■ Бүрэн суманд аймгийн Намын хорооны товчоо мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хэрхэн хангаж байгаа тухай, хурлаараа хэлэлцэж чухал шийдвэр гаргасан юм.

Аймгийн Намын хорооны товчооны хурлын шийдвэрийг биелүүлэх талаар тус сумын намын бүр бүх гишүүдийн ба нийт бригадын хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлэн шуурхай ажлын төлөвлөгөө гаргаж өндөр бүтээлийн 10 хоногийн ажил зохиосноос гадна сумынхаа адуучдын зөвлөлгөөнийг

хийж, юуны өмнө амины ба нийгмийн 13 мянга гаруй адуун сүргийг Гэрэлтийн хөндий, Дааган дэл, Хуц Хайрхан зэрэг газруудад оторт гаргав.

Тус сумын нам, улс, олон нийт, аж ахуйн байгууллага, нийт малчин, хөдөлмөрчид аймгийн намын хорооны товчооны хурлын шийдвэрийг биелүүлэх дэс дараатай арга хэмжээнүүд авч байна.

д.ӨЛЗИЙБИЛЭГ

■ Эрдэнэ суманд БНМАУ-ын кино үйлдвэрийн суртлын бригад ирж, сумын хөдөлмөрчидтэй

уулзалт хийв.

Уулзалт дээр суртлын бригадынхан кино үйлдвэрийн уран бүтээлийн талаар дэлгэрэнгүй ярьж БНМАУ-ын уран сайхны шинэ кино «Тамирын охин», «Найрамдлын дуу» зэрэг кино гаргаж хөдөлмөрчдийн талархлыг хүлээлээ.

У.ЗАГД

■ Зуунмод хотын 5 дугаар хороо ОНАЦ Байцагчдын аймгийн зөвлөлгөөн утгаж бие засах газар 3, муу усны нүх 2-ыг шинээр хийж их цэвэрлэжээ 4 удаа хийлгэж гудамж талбайг засч тэгшлэх ажил зохиов.

САРАНЦЭЦЭГ

ҮЙЛДВЭРЛЭЛ ДЭХ БҮРТГЭЛ НЭВТРЭЛТ

Зөв сайн зохиогдсон бүртгэл нь социалист аж ахуйг төрийн зүгээс удирдан хөгжүүлэхэд намаас дэвшүүлж тавьсан зорилт төлөвлөгөөт даалгаврын биелэлтэнд гүйцэтгэлийн шалгалт хийж үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагааг үр ашгтай зохион байгуулж удирдах социалист эмч хөрөнгийг нэмэгдүүлэн зөв хуваарилж гамтай зарцуулах, дотоод нөөц бололцоог илрүүлэн дайчлах гол хэрэгслүүр болно.

Аймгийн хэмжээгээр ХАА-н байгууллага, үйлдвэр, аж ахуйн газрын анхан шатны бүртгэлийн хөтөлөлт, нэвтрэлтэнд явуулсан үзлэг шалгалт, мэдээнээс үзэхэд Хэрлэн-баян, Улаанбаатар нэгдэл, Батсүмбэрийн САА, Архустын ТАА, Тээврийн удирдах газар, Хүнсний үйлдвэр, Холбооны газруудад анхан шатны бүртгэлийг сайн хөтөлж нэвтр

рэлт нь 98,0—100,0 хувьд хүрсэн байна.

Эдгээр байгууллагуудад анхан шатны бүртгэлийн хөтөлөлт нэвтрэлтийг сайжруулах, улмаар тайлан мэдээллийг хугацаанд нь чанартай гаргаж үйлдвэрлэлийг үнэн зөв бүртгэлийн үндсэн дээр удирдахын тулд бүртгэлийн ажилтнуудын дунд социалист хөдөлмөрийн төлөө бригад байгуулж үүрэг, амлалт авахуулах, уралдаан зарлаж дүгнэх, олон нийтийн байгууллагууд хамтарсан үзлэг шалгалт явуулах, суурь, бригадэд биеллэн туслах, бүртгэлийн тэргүүний ажилтны нийтэд сурталчлах зэрэг олон хэлбэрийн ажлуудыг зохиосон нь үр дүнгээ өгчээ. Тайлан мэдээний гаргалт анхан шатны бүртгэлийн хөтөлөлт нэвтрэлтэнд ажлын ахиц гарч байгаа боловч нийт байгууллагуудад жигд сайжирч чадаагүй байна.

Баянцогтын САА, Залуучуудын хөгжил, Туяа нэгдэл, Замын анги, Дүрслэх салбар зэрэг газруудад анхан шатны бүртгэлийг үйлдвэрлэлд хангалтгүй хөтөлж нэвтрэлт нь дөнгөж 60—66,0 хувьтай байна. Ийнхүү анхан шатны бүртгэлийг ажил гүйлгээ гарсан тухайд нь хөтөлхгүй байгаагаас тайлан мэдээг буруу зөрүү гаргах, хугацаа хожимдуулах, улсын чанартай мэдээ судалгааг саатуулах зэрэг дутагдал гарч байна.

Ийм учраас анхан шатны бүртгэлийн хөтөлөлт нэвтрэлтэнд дүгнэлт хийж социалист эмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт шалгалт, тайлан тооцооны чанарыг эрс сайжруулах ажилд нам, олон нийтийн байгууллага, нийт ажилчин, албан хаагчдын анхаарлыг чиглүүлэх нь чухал.

З.Баянзүл

ХАА-Н НЭГДЛИЙН ХЯНАН БАЙЦААХ КОМИСС

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тогтоолоор сумын ардын хянан шалгах хороо, нэгдлийн хянан байцаах комиссын даргын үүргийг нэг хүн хавсран гүйцэтгэх боллоо.

Сумын ардын хянан шалгах хороо, нэгдлийн хянан байцаах комисс үйл ажиллагаагаа тус тусын дүрэм, зааврыг мөрдлөг болгон явуулна. Сумын ардын хянан шалгах хороо тэндэхийн нам, эвэл, үйлдвэрчний байгууллагаас бусад улс, хоршооллын бүх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд нэгдлийн хянан байцаах комисс нь зөвхөн нэгдлийнхээ хүрээнд хяналт шалгалтын ажлаа явуулах ёстой.

Ардын хянан шалгах хороо, нэгдлийн хянан байцаах комисс нь ажлаа тус тусдаа төлөвлөж тус бүрийнхээ хурлаар асууд

лаа шийдвэрлэж байх боловч ажлын онцгой шаардлагаас хамтарч хуралдах зарим үзлэг шалгалтыг хүч хавсарч хийхээр төлөвлөж болно.

Ардын хянан шалгах хороо, нэгдлийн хянан байцаах комиссын дарга нь дотоод ажлаа өөрөө гардан хариуцаж албан хэрэг материалыаа тус тусад нь хадгалж бичиг хэргийн зааврын дагуу хөтлөх ёстой.

Нэгдлийн үлгэрчилсэн дүрмийн 89 дүгээр зүйлд зааснаар ХАА-н нэгдлийн хянан байцаах комиссыг нэгдлийн зөвлөлийн хурлаас 5—9 хүний бүрэлдэхүүнтэйгээр нууцаар санал хураах журмаар 2 жилийн хугацаагаар сонгодог. Хянан байцаах комисс ажлаа жил, улирлаар төлөвлөн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажлын хуваарийг тодорхой хийж, комиссын

хурлаар батлан протокол хөтлөн мөрдөж ажиллана.

Хянан байцаах комисс сард 1 удаа хуралдаж хэлэлцсэн асуудлынхаа талаар протокол гаргах ёстой. Түүнчлэн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагаанд улиралд 1 удаа, цаг үеийн шаардлагатай ажил болон бригад, хэрсэг, суурь, үйлдвэрлэлийн бусад салбар дээр хугацаа харгалзахгүй шалгалт хийж шалгасан зүйл бүр дээр акт тогтоох бөгөөд уг акт нь албан ёсны баримт болно.

Нэгдлийн хянан байцаах комиссын ажилд бүхий л талаар дэмжлэг үзүүлж социалист өмчийн эсрэг аливаа илрэл, хүнд суртал, хөшүүн хойрго явдлыг илрүүлж мэдээлэн засуулах явдал ХАА-н нэгдлийн малчин, ажилчин, албан хаагчдын эрхэм үүрэг мөн.

Б.ЦОДДОЛ

ИЛГЭЭЛТИЙН ЭЗДИЙН АЖИЛ ҮЙЛС

—Г. Цэцэнбилэг 1971 онд МХЗЭ-ийн илгээлтээр мал аж ахуйн үйлдвэрлэлд гарч 8—10 үнээ хариуцан эхний 3 жилд саалийн төлөвлөгөөг 5740 литр сүүгээр давуулан биелүүлж 1973 онд МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний малчин залуу» алтан медалиар шагнагдаж илгээлтийн эздийн дотроос анхны алтан медальтан болсон юм.

Тэрээр 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд малын зүй бусын хорогдолгүй ажиллах, сүүний төлөвлөгөөг хугацаанаас нь 45 хоногийн өмнө 1194 литр сүү

гээр давуулаад байна.

—МХЗЭ-ийн илгээлтийн эзэн М. Гантулга 1974 онд 10 үнээ хариуцан сааж, хөөвөр хилгасмг бүрэн биелүүлж сүүний төлөвлөгөөг 30 хоногийн өмнө 110 хувиар биелүүлж үүрэг амлалт авч энэ оны эхний 10 сарын байдлаар 11900 литр сүү сааж төлөвлөгөөг 300 литр сүүгээр давуулан 105,6 хувиар биелүүлж илгээлтийн эздийн дотроос анхны мянгат саальчин боллоо.

—Р. Сүхээ 1971 онд МХЗЭ-ийн илгээлтээр нэгдлийн үйлдвэрлэлд гарч ногооноор үр бү

тээлтэй ажиллаж илгээлтийн эхний 2 жилд 08 га газрын ногоо хариуцан бордолт арчлалтыг сайн хийж 190 центнер ургац хураан авч төлөвлөгөөг ургацаас 60 центнер илүү ургац авч 4400 төгрөгийн цэвэр ашиг оруулжээ.

Р.Сүхээ энэхүү амжилтаа бататган 1974 онд 1 га газрын байцааны бүх ажлыг хариуцан тооцоотой үүрэг амлалт авч 1 га-гаас 26 тонн байцаа хураан авч төлөвлөгөөг ургацаас 11 тонн ургац илүү авав.

Н.САНГИРАГЧАА

МОСКВАГИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖ

Төгсгөл. (Түрүүч нь II нүүрт)

юм» гэж Мюнхэн хотын их эмч Юрген Бауш үнэлж байхад «Түргэн тусламжийн албыг үүн шиг зохион байгуулах хэрэгтэй, тэгвэл олон америк хүний амийг аварч чадна» гэж АНУ-ын Пенсильванийн их сургуулийн доктор Патрип Стори үнэлжээ. ЗХУ-ын түргэн тусламжийн алба олон орны түүргэн тусламжийн албаас үнэхээр түрүүлж явна. Зөвлөлтийн эмч нар хүний амийг аварх нь бүхнээс хүндтэй үүрэг гэж үздэг.

Тэд хичнээн өндөр мэргэжил мэдлэгтэй болохоо нэг биш удаа харуулсан юм. Үүнийг олонд нэр гарсан Зөвлөлтийн цуут физикч Лев Ландауд тохиолдсон явдлаар жишээлж болно. 1962 оны 1 дүгээр сарын 7-ны өглөө Москвагаас гарсан машин цөмийн шинжилгээний нэгдсэн институтын хотхон Дубна орохоор хурдац яваад, хальтиргаа замд осолд орж золгүй явдал тохиолдсон билээ.

Хэдэн минутын дараа осол гарсан газар «Түргэн тусламж» очиж тус

хотын клиникийн 50 дугаар больницад осолдогчийг хургасан байна.

Эрдэмтэн Ландауд ухаангүй, түүний бие хоногоо хүлээж байлаа.

Дэлхийн цуут физикч эрдэмтний амийг аврахын тул эмч нар бүхнийг хийж байсан боловч клиникийн үхлээс зайлуулах амжаагүй л... осолд орсон дараа 4 дэх өдөр нь Ландаугийн зүрхийг зогсоож зүүн гарын тараагуур судсанд цус хийж эхлэн, бие мах бодийг үхэлтэй тэмцэхэд «зохиомол уушиг» туслаж байлаа.

Нэг биш 4 удаа сүүлчийн өдөр хүртэл өвчтөний уушиг зүрхийн ажиллагаа дахин зогсох явдал тохиолдож байсан боловч эмч нар үхлийг алж амжилтаар төгслөө.

Есөн долоо хоногийн дараа буюу 1962 оны 3 дугаар сард биенийн хямрал нь ариж сайжирлаа.

Тэр намраа алдарт эрдэмтэн Лев Ландау физикийн шинжлэх ухаанд гарамгай нээлт хийж Нобелийн шагнал хүртсэн билээ.

Д.ОТГОН

Эрлийн шалтгаан юунд байна

Зуунмод хотын 364 номын утсанд залгахад түргэн тусламжийн станц сонсож байна гэж дежурин сувилагч хэлнэ.

Дуудлага өгье гэхэд таниас дөрөвхөн зүйл асууна. Та хичнээн сандарч байсанч тэр дөрөвхөн асуудлыг заавал хариулаарай. Энэ асуудлын ач холбогдол олон дуудлагатай үед очерыг журамлах, хаана хэнд урдаар үйлчлэхийг тогтоох, төрөх, аваар осол, халдварт өвчнөөр өвдсөн, очих газраа эрж будиалгүй байх, түргэн тусламжийн дун бүртгэлийн мэдээ гаргах, үр дүнгүй дуудлага авахгүй байхыг журамлахад туслана.

Ингэснээр түргэн тусламжийн үйлчилгээг хөн

гөн шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй болгоно.

Зуунмод хот маань өрсөжин тэлж байна. Үүнтэй уялдан гудамж хорооллын хаягийг тодорхой болгож шинэчлэн солих шаардлагатай байна.

Одоогийн байдлаар нэг өдрийн дуудлагын 30 хувь нь их, бага ямар нэгэн эрэл хийлгэж байна.

Хашаа нэмж барьснаар гудамжны нэр хаяг нь дундаа орох буюу унаж гээгдсэн, нэг гудамжинд ижил дугаартай хаалга олон болсон нь түргэн тусламж айллыг эрж олоход бэрхшээл учирч байгааг холбогдох байгууллага анхаарч арга хэмжээ авмаар байна.

Түргэн тусламжийн эрхлэгч Г.БААТАР

ТОВЧХОН

Зуунмод хотын ХБ трестийн хүнсний 2 дугаар дэлгүүрийн хамт олон 1974 оны 11 дүгээр сарын төлөвлөгөөг хугацаанаас нь 12 хоногийн өмнө амлалт үүргээр 108 хувь буюу 4,7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж сайхан амжилт гаргав.

ГАЛЯ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б.ЦЭГЭНДАШ

ЗАРЛАЛ

Лүн сумын харьяат Дулам овогтой Төмөрчөдөр, Сэрээнхорол овогтой Лхамсүрэн, Замар сумын харьяат Цэндсүрэн овогтой Шаалай, Даш овогтой Юмжир нарын гэрлэлтээ цуцлуулахаар сэдэж гарсан өргөдлийг аймгийн 4 дүгээр шүүх хянаж байна.

Эрдэнэсант сумын харьяат Гомбосүрэн овогтой Тогоохүү нь иргэний 334933 тоот үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.